



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2019 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 212

Улаанбаатар хот

“Хөдөө аж ахуйн бирж” хязгаарлагдмал хариуцлагатай  
компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл  
хэрэгжүүлж буй гишүүдийг чөлөөлөх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь заалт, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”-ын 2.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Хөдөө аж ахуйн бирж” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүн Э.Сумьяа /Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын ахлах референт/, А.Гэрэлзаяа /Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны ахлах мэргэжилтэн/, Б.Эрдэнэбулган /Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн/, С.Энхзориг /Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын мэргэжилтэн/ нарыг 2019 оны 05 дугаар сарын 21-ний өдрөөр тасалбар болгон чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД